

## **Олон Улсын Валютын Сан**

### **Товчхондоо**

*Олон Улсын Валютын Сан (ОУВС) нь олон улсын санхүүгийн тогтвортой байдал болон валютын хамтын ажиллагааг дэмждэг байгууллага юм. Мөн түүнчлэн олон улсын худалдааг хөнгөвчлэх, эдийн засгийн тогтвортой өсөлт болон ажлын байр бий болгохыг дэмжиж, дэлхий дахинаа ядуурлыг бууруулахад үйл ажиллагаагаа чиглүүлдэг. ОУВС нь өөрийн гишүүн нийт 189 орны удирдлаган доор үйл ажиллагаагаа явуулж мөн тэдэнд тайлагнадаг.*

“Сан” ч гэж нэрлэгддэг ОУВС байгуулагдах эхлэл анх 1944 оны 7-р сард АНУ-ын Нью-Хэмпшир мужийн Бреттон Вүүдс-т болж өнгөрсөн НҮБ-ын хуралдааны үеэр тавигдсан бөгөөд энэхүү санаачлага гарах болсон шалтгаан нь 1930-аад оны их хямралыг дагуулсан ханшийн өрсөлдөөнт девальвацийг дахин давтуулахгүй байх үүднээс эдийн засгийн хамтын ажиллагааны механизм шаардлагай хэмээн оролцогч 44 улс орон үзсэнтэй холбоотой юм.

**ОУВС-гийн үндсэн үүрэг:** Тус байгууллагын үндсэн гол үүрэг нь олон улсын мөнгө, валютын систем буюу улс орнууд (болон тэдний иргэд) хоорондын эдийн засгийн харилцаанд ашиглагдах ханш, олон улсын төлбөр тооцооны системийн тогтвортой байдлыг хангахад оршдог.

**Хяналтын чиг үүрэг:** Олон улсын мөнгө, валютын тогтолцооны тогтвортой байдлыг сахиж, хямралаас урьдчилан сэргийлэх зорилгоор ОУВС гишүүн орнуудынхаа холбогдох бодлого төдийгүй дэлхий, бүс нутаг, үндэсний эдийн засаг, санхүүгийн амьдралд “тандалт судалгаа” хэмээх албан ёсны тогтолцоогоороо дамжуулан байнгын хяналт тавьж ажилладаг. Түүнчлэн, гишүүн 189 оронд зохих дэмжлэг зөвлөгөөг хүргүүлдэг бөгөөд эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, эдийн засаг, санхүүгийн хямралд өртөмтгий бус байх нөхцлийг бүрдүүлэх, амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого хэрэгжүүлэхийг зөвлөдөг. Дэлхийн эдийн засгийн төлөв хандлагын талаарх төсөөллийг “Дэлхийн эдийн засгийн төлөв” тайлан, санхүүгийн зах зээлийн чиг хандлагын талаарх тойм мэдээллийг “Дэлхийн санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал” тайлангаараа дамжуулан тогтмол гаргадаг бол төрийн төсөв санхүүгийн холбогдолтой мэдээллийг “Төсвийн мониторингийн тайлан” тайлангаараа дамжуулан хүргүүлдэг бөгөөд бүсийн эдийн засгийн төлөв сэдвээрх цуврал нийтлэлүүдийг мөн гаргадаг.

**Санхүүгийн дэмжлэг:** ОУВС нь гишүүн орнууддаа төлбөрийн тэнцэлтэй холбоотой хүндрэлээс гарах боломжийг олгодог бөгөөд энэ хүрээнд дэмжлэг авч буй орны эрх баригчид ОУВС-тай нягт хамтран ажиллах байдлаар ОУВС-гаас санхүүжигдэх “тохиргоо хийх хөтөлбөр” боловсруулах бөгөөд тухайн хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлаас хамааран санхүүжилт үргэлжлэн олгогдох эсэх нь шийдэгддэг. Дэлхийн санхүү эдийн засгийн хямралын дараагаар ОУВС зээл олгох чадавхиа бэхжүүлээд зогсохгүй санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга механизмдаа томоохон шинэчлэл хийх шийдвэрийг 2009 оны 4-р сард гаргаж, 2010, 2011 онуудад нэмэлт шинэчлэлийг мөн хэрэгжүүлсэн. Энэхүү шинэчлэл нь хямралаас урьдчилан сэргийлэх, системийн шинжтэй хямралын үед эрсдэл халдварлах магадлалыг бууруулах, гишүүн орнуудын үзүүлэлт, нөхцөл байдлаас хамааран арга хэрэгслийг тохируулан боловсруулах зэрэг асуудлуудад голчлон анхаарсан. Квотыг хянан хэлэлцэх 14 дэх удаагийн хэлэлцээрийн дагуу хүчин төгөлдөр болсон квотын өсөлтийн үр дүнд ОУВС-гийн ердийн эх үүсвэрээс олгогдох санхүүжилтэд тавигдах дээд хязгаарын асуудлыг эргэн хэлэлцэж, 2016 оны эхээр босгыг өсдөрсөгсөн болно. Дэлхийн хамгийн ядуу буурай орнуудад олгох санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлэх зорилгоор Ядуурлыг бууруулах, өсөлтийг дэмжих итгэлцлийн сангаар дамжин бага орлоготой орнуудад олгогддог хөнгөлөлттэй эх

үүсвэрийг 2009 онд үлэмж нэмэгдүүлсэн бөгөөд хөнгөлөлттэй эх үүсвэрээс олгогдох санхүүжилтэд хамаарах дээд хязгаарын дундаж хэмжээг нэг дахин өсгөсөн болно. Мөн түүнчлэн, зээлжих эрхийн норм, хязгаарыг 2015 онд 50 хувиар өсгөснийг дурдах нь зүйтэй. Энэхүү зээл нь 2018 оныг дуустал хүүгүй олгогдох санхүүжилт бол онцгой байдалд олгогдох санхүүжилт байнгын тэг хувийн хүүтэйгээр олгогддог. Эцэст нь тэмдэглэхэд, ОУВС хөнгөлөлттэй зээл олгох өөрийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор 15 тэрбум ам.доллар (11 тэрбум зээлжих тусгай эрх)-ын зээлийн нэмэлт эх үүсвэрийг бүрдүүлэхээр одоо чармайн ажиллаж байна.

**Чадавхи бэхжүүлэх:** Гишүүн орнуудын үр дүнтэй бодлого, үүний дотор татварын оновчтой бодлого, удирдлага, төсвийн зарлагын удирдлага, мөнгөний болон ханшийн бодлого, банк, санхүүгийн системийн хяналт шалгалт, зохицуулалт, хууль эрх зүйн орчин, статистикийн тогтолцоотой холбогдох бодлого боловсруулан хэрэгжүүлэх чадавхийг дэмжих үүднээс ОУВС-гаас тодорхой арга хэмжээ авч сургалт зохион байгуулдаг.

**Зээлжих тусгай эрх:** Гадаад валютын нөөцийн активын нэг хэлбэр болох ОУВС-гаас гаргадаг зээлжих тусгай эрх (ЗТЭ) нь гишүүн орнуудын гадаад валютын албан нөөцийг зузаатгах ач холбогдолтой. Өнөөдрийн байдлаар нийт 286 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний 204 тэрбум ЗТЭ-ийг гаргаад байгаа бөгөөд гишүүн орнууд хоорондоо ЗТЭ-ийг валютаар солих чөлөөт арилжааг сайн дурын үндсэн дээр хийх эрхтэй.

**Эх үүсвэр:** ОУВС-гийн санхүүгийн эх үүсвэрийн гол эх сурвалж нь дэлхийн эдийн засагт гишүүн орнуудын эзлэх байр суурийн харьцангуй илэрхийлэл болсон квотууд байдаг билээ. Квотыг хянан хэлэлцэх 14 дэх удаагийн хэлэлцээр хүчин төгөлдөр болсноор квотын нийт эх үүсвэр 477 тэрбум орчим ЗТЭ (668 тэрбум орчим ам.долл) болж өссөн. Квотын эх үүсвэрийг нөхөх зориулалттай түр хугацааны зээлийн санхүүжилт авах боломж ОУВС-д мөн байдаг бөгөөд Зээлжих шинэ зохицуулалт (ЗШЗ) буюу 182 тэрбум (254 тэрбум орчим ам.долл) хүртэлх хэмжээний ЗТЭ босгох боломжтой механизм нь квотыг дэмжих гол эх үүсвэр юм. 2012 оны дунд үед хоёр талт зээлийн хэлэлцээрээр ОУВС-гийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх үүрэг амлалтуудыг гишүүн орнуудаас авсан бөгөөд өнөөдрийн байдлаар 280 тэрбум ЗТЭ (393 тэрбум а.долл)-ийн дүн бүхий гэрээ хүчин төгөлдөр болсон байна.

**Засаглал, зохион байгуулалт:** ОУВС нь гишүүн орнуудын засгийн газрын өмнө хариуцлага хүлээж ажилладаг бөгөөд тус байгууллагын шийдвэр гаргах дээд эрхийг гишүүн орон тус бүрийн гол төлөв төв банк, сангийн яамыг төлөөлөх Захирагч болон Дэд захирагч нараас бүрдсэн Захирагч нарын зөвлөл хэрэгжүүлнэ. Захирагч нарын зөвлөл жил бүр ОУВС-Дэлхийн банкны хамтарсан хуралдааны үеэр хуран чуулах бөгөөд захирагч нарын 24 нь жилд дунжаар хоёр удаа хуралддаг Олон Улсын Валют, Санхүүгийн Хорооны гишүүн байдаг.

ОУВС-гийн өдөр тутмын үйл ажиллагааг гишүүн орнуудыг бүхэлд нь төлөөлөх 24 гишүүн бүхий Захирлуудын зөвлөл хариуцан ажиллах бөгөөд зөвлөлийн үйл ажиллагааг ОУВСХ-ноос удирдан чиглүүлнэ. Энэ бүх үйл ажиллагаа нь ОУВС-гийн нийт ажилтнуудын оролцоо дэмжлэгтэйгээр хэрэгжих бөгөөд тэднийг хариуцах гол албан тушаалтан нь Тэргүүн юм. Сангийн Тэргүүн нь Захирлуудын зөвлөлийн Даргын үүрэг гүйцэтгэх бөгөөд түүнийг дөрвөн дэд тэргүүн дэмжин ажилладаг.

## **ОУВС-гийн тухай баримтын хураангуй**

Гишүүн улсын тоо: 189 улс

Төв оффис: Вашингтон хот

Захирлуудын зөвлөл: нэг эсвэл хэд хэдэн улсыг төлөөлөх 24 захирлаас бүрдэнэ

Ажилтны тоо: 148 улсын харъяат 2,700 орчим ажилтан

Нийт квот: 668 тэрбум ам.доллар (2016 оны 9-р сарын 13-ны байдлаар)

Амласан эсвэл нээлттэй нэмэлт эх үүсвэр: 668 тэрбум ам.доллар

Идэвхтэй зээлийн гэрээний хүрээнд нээлттэй болгосон эх үүсвэр (2016 оны 9-р сарын 8-ны байдлаар): 159 тэрбум ам.доллар ба үүнээс 144 тэрбум ам. долларыг ашиглаагүй байгаа (хүснэгтээс харна уу)

Хамгийн том зээлдэгчид (2016 оны 8-р сарын 31-ний байдлаарх зээлийн үлдэгдэл): Португал, Грек, Украин, Пакистан улсууд

Урьдчилан сэргийлэх зорилготой хөтөлбөрийн хамгийн том зээлдэгчид (2016 оны 9-р сарын 8-ны байдлаарх харилцан тохирсон дүн): Мексик, Польш, Колумб, Морокко улсууд

Тандалт судалгааны хүрээнд хийгдсэн хэлэлцүүлгийн тоо: 2013 онд 130, 2014 онд 132, 2015 онд 124

Чадавхи бэхжүүлэх үйл ажиллагаа: 2013 оны санхүүгийн жилд 274 хүн-жил, 2014 онд 285 хүн-жил, 2015 онд 288 хүн-жилийн үйл ажиллагаа хийгдсэн

Анхдагч эрхэм зорилгууд:

- мөнгө, валютын олон улсын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих
- олон улсын худалдааг өргөжүүлэх, тэнцвэртэй өсөлтийг нь хангахад бодитой хувь нэмэр оруулах
- ханшийн тогтвортой байдлыг дэмжих
- олон талт төлбөрийн системийг үүсгэн байгуулахад дэмжлэг үзүүлэх
- (зохистой хамгаалалтын хүрээнд) төлбөрийн тэнцлийн хүндрэлтэй тулгарсан гишүүн орнуудад хөрөнгийн эх үүсвэрийг нээлттэй болгох.